

Петро Матад Лимитед
(“Петро Матад” эсвэл “Компани”)
Давсан Толгой дох Ажиллагааг Түр Зогсоох Тухай

Дорнод аймагт малын гар, хөл ба амны өвчин тархсантай холбоотойгоор Давсан Толгой дох ХХ блок дээрх ДТ-1 цооногийн өрөмдлөгийн ажлыг эхлэх бэлтгэлийг Петро Матад түр хугацаагаар зогсоож байгаа болно.

Дорнод аймагт ялангуяа Матад сумын захиргааны орчимд гар, хөл ба амны өвчин тархсантай холбоотойгоор Дорнод аймгийн Засаг дарга 22 тоот албан тушаал гарган тус газарт орох гарах машин боломжгүй хөдөлгөөнийг хязгаарлаад байна. Хөдөлгөөнийг тийнхүү хорисноос хангамжийн машинууд ДТ-1 талбайд үрэх бололцоогүй болж байгаагаас гадна талбай дээрх ажиллагсад талбайг орхин явж болохгүй болоод байна. Одоогийн байдлаар энэхүү Тушаал нь 2010 оны 6 сарын 9 хүртэл хүчинтэй байх ажээ.

ДТ-1 цооногийг өрөмдөх ажил гарцаагүй шаардлагатай байгаа хэдий ч хөдөлгөөнийг тийнхүү хязгаарласан үед өрөмдлөгийн ажлыг эхүүлэх нь инженерингийн, ложистикийн болон аюулгүй ажиллагааны үүднээс боломжгүй гэсэн шийдвэр тус Компани гаргаад байна. Компанийүндсэн баг Хятадын өрөмдлөгийн багийн бүрэн бүрэлдэхүүний хамтаар талбай дээр үлдэх болно. Талбайн багийнхан өрөмдлөгийн машин дээр аль болох их засварйлчилгээ болон бэлтгэл ажлууд хийж амжуулах болно.

Гүйцэтгэх захирал Дуглас МкКэй хэлэхдээ “Компаний удирдлага болон хувьцаа эзэмшигчдийн хувьд энэхүү саатал нь цагаа олоогүй маш сэтгэл гонсойлгосон хэрэг хэдий ч бидниййл ажиллагаа явуулж байгаа нутагт энэхүү аюултай өвчнийг хязгаарлан зогсоох, арилгах ажлыг хангахын тулд орон нутгийн үүрэг б байгууллагуудтай бид бүрэн хамтран ажиллах болно. Манай үйл ажиллагаа явуулж буй нутгийн мал болон малчдын цаашилбал майнаёөрсдийн болон гэрээлэгчдийн ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах нь илүү чухал юм. Дараагийн 10 хоногийн хугацаанд бид хяналт тавьж туслалцаа үзүүлэх бөгөөд энэ асуудал түргэн шийдэгдэж үйл ажиллагаагаа дахин эхлүүлнэ гэж найдаж байна” гэж хэлсэн.

Редакторуудад зориулсан санамж:

Петро Матадын тухай

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурвантэбгдхүүн Хуваах Гэрээнүүдийг дангаараа гүйцэтгэгч байгууллага болно. Гол хөрөнгө нь тус орны алс дорнодод байрлах 14,250 квадрат км талбайг газрын тосны ХХ блокд байгуулсан Бүтээгдхүүн Хуваах Гэрээт талбай. Нөгөө хоёр 4 ба 5 -р блокууд нь Монгол улсын төв хэсэгт байрлах бөгөөд хамтдаа 73,498 квадрат км талбайтай.

Петро Матад Лимитед компани нь Мэн аралд 1483В гэсэн бүртгэлтэй байгуулагдсан компани бөгөөд албан ёсны бүртгэлтэй төв байр нь Виктори Байшин, Проспет Хилл, Дуглас, Мэн, Ай Эм 1 –ИКю хаягт байрладаг болно.

Цаашдын мэдээллийг дараах хаягаар авч болно:

Петро Матад Лимитед
Дуглас Жэй. МкГэй- Гүйцэтгэх Захирал +976-11-331099

Вестхаус Секюритис Лимитед
Ричард Бэйти / Петре Нортон +44/0/ 20 7601 6100

Банкны талын зөвлөхүүд
Саймон Розсчайлд / Оливер Винтерс / Луйс Мэйсон +44/0/ 20 7367 8888